ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр Дугаар А/96 Арвайхээр сум

Б.Баярхүүгийн газар эзэмших эрхийг
Г.Сүнжидмаад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигчийн гаргасан хүсэлтийн дагуу тус сумын Эмт 2 дугаар багийн 2 дугаар гудамжны 18 тоотод байрлах Батсуурийн Баярхүүгийн эзэмшлийн 6216015741 нэгж талбарын дугаартай, 8 жилийн эрхийн гэрчилгээний хугацаатай, 254 м2 хэмжээ бүхий гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай газар эзэмших эрхийг Ганболдын Сүнжидмаад шилжүүлсүгэй.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны “Газар эзэмшлийн эрх шилжүүлэх тухай” А/83 дугаар захирамжийн Б.Баярхүүтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцсон татварын баримт болон газрын эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (Ш.Адъяадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

62251235